

“МОНГОЛ ДААТГАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

“Монгол даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн заалтууд, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам” болон холбогдох хууль тогтоомжийн дагуу 2020 оны 4 сарын 15-ны өдрийн 15:00 цагаас Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, “Монгол даатгал” ХК байр, 3 давхарт хурлын танхимд цахим хэлбэрээр хийлээ.

Хурлын дарга Б.Аюуш: “Монгол даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн цахим хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг компанийн тухай хуульд нийцүүлэн гаргасан байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Огай Наталья Юрьевна Улаанбаатар хотод байхгүй байгаа учраас Б.Аюуш намайг хурлыг удирдуулахаар томилсон. Үүний дагуу би хурлыг удирдаж явуулах болно. Хурал маань цахим хэлбэрээр явагдаж байгаа онцлогтой учраас урьдчилан ирүүлсэн “Саналын хуудас”-нуудыг Санал хураах хайрцагт хадгалсан байгаа. Хуралд “Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, “Монгол Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал **Ч.Энх-Амгалан**, “Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-д нэр дэвшигч Үйл ажиллагааны газрын захирал бөгөөд энэ удаагийн хуралд бэлтгэх комиссын дарга **О.Эрдэнэбулган**, “Гендекс ҮЦК” ХХК-ийн **Ч.Бат-Өлзий**, **Д.Дэлгэрмаа** нар биеэр, “Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч **Ц.Оюунжаргал**, “Би Ди Сек” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч **Б.Азбаяр**, **хувьцаа эзэмшигч Э.Золзаяа** нар цахимаар хуралд оролцож байна.

Санал хураах хайрцгийг нээж байж хурлын ирцийг тогтоох болно. Тооллогын комисс цахимаар оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэд харуулан хайрцагаа нээнэ үү.

Тооллогын комиссын дарга **Ч.Бат-Өлзий**, гишүүн **Д.Дэлгэрмаа** нар санал хураах хайрцагийн битүүмжлэлийг задалж, хайрцгийг нээлээ. Хайрцагнаас 2 саналын хуудас гарлаа.

Б.Аюуш: Хуралд цахимаар оролцож байгаа “Би Ди Сек” ҮЦК саналаа хуудсаа ирүүлээгүй юм байна. Одоо саналын хуудсаа бөглөөд мэйлээр ирүүлээрэй.

“Би Ди Сек” ҮЦК-ийг төлөөлөн оролцож байгаа итгэмжлэгдсэн төлөөлөгч **Б.Азбаяр:** Би удирдлагаас санал өгөх чиглэл аваагүй учраас саналын хуудсаа явуулах боломжгүй байна, энэ удаад мэдээлэл авах зорилгоор хуралд оролцоё.

Б.Аюуш. Хуралд оролцож байгаа боловч санал өгөх боломжгүй учраас шийдвэр гаргах асуудлаар “түдгэлзсэн” гэж үзээд тооллогын дүн гаргаарай.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий:

“Монгол Даатгал” ХК нь нийт 64’132’341 ширхэг хувьцаатай, үүнээс 109’300 ширхэг халаасны хувьцаатай буюу саналын эрхтэй 64’023’041 ширхэг хувьцаатай, саналын хайрцагнаас нийт 2 саналын хуудас гарлаа. Нийт 261 хувьцаа эзэмшигч байгаа.

“Миллениум Секьюритиз Менежмент Лимитед” компани 63’997’215 ширхэг хувьцаатай, **Э.Золзаяа** 110 ширхэг хувьцаатай, цахимаар оролцож байгаа “Би Ди Сек” ХХК 97 ширхэг

хувьцаатай байна. Нийт саналын эрхтэй 63,997,422 ширхэг хувьцаатай буюу 99.9 хувийн ирцтэй байна.

“Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын анхдугаар тогтоолыг танилцууллаа.

Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч:

Саналын эрх бүхий нийт хувьцааны 99.9 хувийг эзэмшигч “Милленниум Секьюритиз Менежмент Лимитед” компанийг төлөөлөлж **Л.Таня**, иргэн **Э.Золзаяа** нар саналын хуудсаар, “Би Ди Сек” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч **Б.Азбаяр** цахимаар /онлайн/ хуралд оролцсоноос гадна “Монгол Даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал **Ч.Энх-Амгалан** нар оролцов.

Хурал даргалагч **Б.Аюуш** ээлжит хурлын хүчин төгөлдөрт тооцох ирц хүрсэн учраас хурлаа нээлээ гээд, ээлжит хурал хуралдуулах тухай Монгол Даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн тогтоолыг болон уг тогтоолоор баталсан хурлын дэгийг танилцуулав.

Хурлаар хэлэлцэх асуудлуудын материалыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Бидний хэлэлцэх эхний асуудал бол “Монгол Даатгал” ХК-ийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт юм.

Хурлын дарга Б.Аюуш: “Монгол Даатгал” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хувийг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд оруулсан.

“Монгол Даатгал” ХК-ийн хувьд өнгөрсөн жил онцгой өөрчлөлт гарсан жил байлаа. Өмнө нь хаалттай ХХК байсан бол хөрөнгийн биржид бүртгэлтэй “Хорго Хайрхан” ХК-д нэгдэх замаар нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсан. Өөрчлөн байгуулагдахтай зэрэгцээд компанийн гүйцэтгэх удирдлагын баг үндсэндээ шинэчлэгдсэн. Ийнхүү компанийн хувьд том өөрчлөлтэй жил байлаа. Үүнээс улбаалаад Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын бүртгэлд нээлттэй компани болсноо бүртгүүлсэн. Нээлттэй компанийн гол онцлог нь үйл ажиллагаа нь нээлттэй, сайн засаглалтай байх ёстой. Засаглалаа сайжруулахтай холбоотойгоор компанийн засаглалын кодекс заасан бүх дүрэм, журмуудыг баталсан. Өнгөрсөн онд үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд өөрчлөлтийн талаар дэлгэцэн дээр та бүхэнд харуулсан байгаа. Компанийн даатгалын зах зээлд эзлэх хувь 17% байна. Өнгөрсөн оны энэ хувь хэмжээ өөрчлөгдөөгүй хэвээрээ байгаа. Даатгалын салбар 2018 онтой харьцуулахад 41% өссөн. Компанийн хувьд бол 23%-иар өссөн үзүүлэлттэй байна. Даатгалын компанийн үндсэн үзүүлэлт болох хураамж өнгөрсөн онтой харьцуулахад өсч 32.6 тэрбумд хүрсэн. Нийт хөрөнгийн хэмжээ 43.3 тэрбумд хүрч 10 гаруй тэрбумаар өссөн. Ажиллагсдын тоо өнгөрсөн онтой харьцуулахад 9 хүнээр цөөрсөн учраас нэгж хүнд ногдох хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэн. Нөхөн төлбөрийн хувьд үзүүлэлтүүд өссөн. Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд өсөлттэй байлаа. Татвар хураамж, нийгмийн хариуцлагын хүрээнд нийтдээ 42.4 сая төгрөг зарцуулсан. Эдийн засгийн чанарын үзүүлэлтүүд өсөлт, бууралттай жил байлаа. Ерөнхийдөө 2019 онд компанийн санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд хэвийн байсан. Даатгалын зах зээлд шинэлэг гэж хэлж болохоор зарим нэг бүтээгдэхүүн, технологийн өөрчлөлтүүд гарсан байгаа. Жишээ нь, хиймэл оюун ухаанд суурилсан фейсбүүк чатботыг ажиллуулж эхэлсэн, даатгал хийх болон даатгалын тохиолдлыг бүртгэхэд даатгуулагчдад хялбар, түргэн шүүрхай үйлчилгээ үзүүлэх боломж бүхий видео ассистент системийг нэвтрүүлсэн. Түүнээс гадна 2019 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулахаар “Фискал аудит” компанийг ТУЗ-аас сонгож гэрээ байгуулсан. Энэ компани санхүүгийн тайланд шалгалт хийгээд 2019 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээг олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан гэсэн дүгнэлтийг

өгсөн байгаа. Зарим нэг үйл ажиллагааны зардал өссөн нь орлогын өсөлттэй урамшуулалын зардал, ТУЗ-ийн гадаад томилолт, эрсдлийн бодлоготой уялдан багцын давхар даатгалын зардал өмнөх үеийнхээс 2 дахин өссөнтэй холбоотой гэсэн байна. Компани биржэд 3 дугаар самбарт байршсан. Хувьцааны үнэ ханшийн хувьд та бүхний анхаарах асуудал байгаа. Компани нэгдэж цоо шинэ компани байгуулагдаж байгаа боловч хуучин “Хорго Хайрхан” гэж үйл ажиллагаа нь зогсчихсон компанитай нэгдсэн учраас хувьцааны үнийг хуучин компанийн хаалтын ханшнаас тооцож явуулдаг журамтай учраас хувьцааны арилжаатай холбоотой асуудал үүсч байсан. Хуучин “Хорго Хайрхан” ХК-ийн хаалтын ханш 70 төгрөг байсан бол өнөөдрийн байдлаар “Монгол Даатгал” ХК-ийн хаалтын ханш 1500 төгрөгийн ханштай байгаа. ХК-ийн хувьд хувьцааны арилжааны ханш олон зүйлийг илэрхийлдэг үзүүлэлтүүд байдаг. Компанийн удирдлагын хувьд хувьцааны арилжаа идэвхтэй байх, хувьцааны арилжааны ханшийн өсөлтөнд анхаарал хандуулах шаардлагатай болдог. Энэ бүх үзүүлэлтүүдээс үндэслээд ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хангалттай сайн ажилласан гэж дүгнээд удирдлагын багийг удирдан ажиллаж байгаа гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээг сунгах зөвшөөрлийг ТУЗ-д өгсөн байгаа. Мөн санхүүгийн тайланг олон улсын стандартын дагуу үнэн бодитоор илэрхийлсэн гэсэн “Фискал аудит” хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтийг зөвшөөрөх саналыг гаргасан. Энэ дүгнэлтийг зөвшөөрөх эсэх саналаа хувьцаа эзэмшигч та бүхэн өгөх болно.

Хурлын дарга Б.Аюуш: Дараагийн хэлэлцэх асуудал бол компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудал байгаа. Компанийг нэгтгэх явцад “Хорго Хайрхан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг болох үедээ энэ дүрмээр ажилладаг болно гээд баталсан дүрэм байгаа. Дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлсэн. Компани нэгдсэнээс хойш эргэж харах зүйлсүүд их байсан учраас дүрэмд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн. 85 жилийн түүхтэй компани учраас Монгол орны өнцөг булан бүрт салбартай. Зарим салбарууд өөрийн гэсэн үл хөдлөх хөрөнгөтэй. Тэр үл хөдлөх хөрөнгийн зарим ашиглахгүй байгаа хэсгийг түрээслэж орлого олох боломжтой байдаг. Тиймээс үйл ажиллагааны чиглэл дээр түрээсийн үйл ажиллагааг нэмэлтээр оруулах шаардлагатай болсон.

Түүнээс гадна үйл ажиллагааны чиглэл гэдэгт бүтээгдэхүүнүүдээ бүгдийг нь жагсаагаад биччихсэн. Гэтэл үйл ажиллагааны чиглэлийг тэмдэглэхдээ ердийн даатгал гэдэг нэг үйл ажиллагааны төрлийг тавьдаг. Даатгалын бүтээгдэхүүнийг бид дүрмэндээ заасан учраас СЗХорооноос шинэ бүтээгдэхүүний зөвшөөрөл авах болгондоо дүрмэндээ өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байсан учир өөрчилсөн.

Мөн ТУЗ гүйцэтгэх захирлыг томилдог. Гүйцэтгэх захирал ТУЗ-д тайлагнадаг. ТУЗ-ийн өмнө гүйцэтгэх захирал хариуцлага хүлээдэг. Тэгэхээр Гүйцэтгэх захирал нь өдөр тутмын үндсэн үйл ажиллагааны талаарх бүх хариуцлагыг хүлээдэг. Гэтэл гүйцэтгэх удирдлагад байвал зохих зарим нэг эрх мэдлийг ТУЗ-д шилжүүлчихсэн. Тэр нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай явуулахад саад болохоор нилээдгүй заалтууд байсныг өөрчлөх тухай саналыг ТУЗ-ийн хурлыг хуралдах үед гаргасан байсныг санал өгсөн хувьцаа эзэмшигч нар болон ТУЗ-ийн гишүүд зөвшөөрсөн байгаа. Гэх мэт өөрчлөлтүүдийг дүрэмд оруулах санал оруулсан байгаа юм. Та бүхэн саналаа өгөөрэй.

Мөн, бидний хэлэлцэх дараагийн асуудал байна. Монгол улсын Компанийн тухай хуулинд 2012 онд орсон өөрчлөлтөд хувьцаат компанийн үйл ажиллагаа нээлттэй буюу сайн засаглалын зарчмуудыг дагаж мөрдөхөд чиглэсэн олон өөрчлөлтүүд оруулсан байдаг. Үүнд нийцүүлээд СЗХорооноос компанийн засаглалын кодексийг баталсан. Энэ кодексийг мөрдөхийн тулд нээлттэй ХК-иуд доод тал нь 5 журмыг дагаж мөрдөх шаардлагатай байдаг. Энэ журмуудыг ТУЗ батлаад мөрдүүлдэг. Харин “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай” журмыг компанийн засаглалын кодексд хувьцаа эзэмшигчдийн хурал батална гэж заасан

байдаг. Компанийн тухай хуульд ХЭХурлыг хуралдуулахтай холбоотой маш нарийн зохицуулалтууд байдаг. Гэсэн хэдий ч тусгай журам гарган мөрдүүлснээр хурлыг үр дүнтэй зохион байгуулан явуулах, ялангуяа хурлын материал нь хувьцаа эзэмшигчдэд хангалттай мэдээлэл өгөхүйц байх ёстой. Ийм учраас Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексд нийцсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн засаглалын зарчимд нийцсэн журмын төсөл боловсруулж Та бүхнээр батлуулахаар толилуулж байгаа. Ер нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шаардлага нь юу байна гэхээр нээлттэй ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьд компанийн амьдралд гарч байгаа маш чухал үйл явдал байдаг. Компанийн бүхий л мэдээллийг авах боломжийг олгодог чухал үйл явдал байдаг учраас энэ үйл явдлыг нарийвчлан зохицуулдаг журам байх ёстой гэж үзээд та бүхэнд толилуулж байгаа юм.

Хурлын дарга Б.Аюуш: Дараагийн хэлэлцэх асуудал бол ТУЗ-д нэр дэвшигчдийг танилцуулаад, ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал байгаа. Гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар саналын хуудсыг бөглөнө. 2 хүн саналаа өгсөн байгаа. Компанийн ТУЗ-д чадварлаг, салбартаа өндөр түршлагатай бүрэлдэхүүн томилогдож байгаа.

1. ТУЗ-ийн ердийн гишүүнд “Миллениум Секьюритиз Менежмент Лимитед” компанийг төлөөлөөд Громов Сергей Борисович, Огай Наталья Юрьевна, Лизунова Таня нар, “Монгол даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Энх-Амгалан, тус компанийн үйл ажиллагаа хариуцсан газрын захирал О.Эрдэнэбулган, Байгууллагын даатгалын бизнесийн газрын захирал Т.Баасанжав нар нэр дэвшиж байна.

2. ТУЗ-ийн хараат бүс гишүүнд О.Цогт, Ц.Оюунжаргал, Д.Отгонбат нар нэр дэвшиж байна. Хурлын материалд болон МХБ-ийн цахим хуудсанд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулсан байгаа.

Асуух зүйл байна уу гэв. Хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хувьцаа эзэмшигч нарт санал өгөх хуудсанд санал өгөх журмыг тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий танилцуулахаар болов.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий: Хувьцаа эзэмшигчид санал өгөх журмыг тайлбарлав.

Дараа нь тооллогын комисс санал тоолох ажилдаа орж, хуралд тооллогын дүнг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын дүн дараах байдалтай байна. Нийт 63'997'423 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид саналаа өгч хэлэлцсэн бүх асуудлаар 100 хувийн саналаар зөвшөөрсөн байна. татгалзсан санал байхгүй, түдгэлзсэн санал байхгүй тул баталсанд тооцов.

Хурлын дарга Б.Аюуш: Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэн хурлаас гарах шийдвэрүүдийг танилцуулав.

Нэгдүгээр асуудлаар: Компанийн тухай хуулийн 62.1.9, 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн ХЭХурлын тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг үндэслэн тогтоох нь:

Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Монгол Даатгал” ХК-ийн 2019 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хоёрдугаар асуудлаар:

Дараах нэр бүхий гишүүдийг **ТУЗ-ийн Ердийн гишүүнээр:**

1. Громов Сергей Борисович,
2. Огай Наталья Юрьевна,
3. Лизунова Таня,
4. Ч.Энх-Амгалан,
5. О.Эрдэнэбулган,
6. Т.Баасанжав нарыг сонгосугай.

Хараат бус гишүүнээр:

1. О.Цогт,
2. Ц.Оюунжаргал,
3. Д.Отгонбат нарыг сонгосугай

Компанийн эрх ашгийг дээдлэн, компанийн тухай хууль тогтоомж, ТУЗ-ийн үйл ажиллагааны дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

Гуравдугаар асуудлаар:

ТУЗ-ийн төсвийг хавсралтаар баталсугай. ТУЗ-ийн төсвийг чанд мөрдөн ажиллахыг ТУЗ-ийн даргад даалгасугай.

Дөрөвдүгээр асуудлаар:

Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг баталсугай. Компанийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1, 3.2.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.1 дэхь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.53 болон 7.61 дэхь хэсэг, мөн зүйлийн 7.32.6, 7.32.14, 7.54.1, 7.60.2, 7.60.6 дахь заалтуудыг хавсралтад зааснаар өөрчилсүгэй. Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Улсын бүртгэлд даалгахыг "Монгол Даатгал" ХК-ийн үйл ажиллагааны газарт даалгасугай.

Тавдугаар асуудлаар:

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журмыг хавсралтаар баталсугай. ХЭХ-ийг зарлах, бэлтгэлийг хангах, хуралдуулахдаа энэ журмыг чанд мөрдөн ажиллахыг ТУЗ, компанийн удирдлага, хурал зохион байгуулах комиссд үүрэг болгосугай.

Дээрх 5 тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан болохыг та бүхэнд мэдэгдлээ.

Хурлын дарга Б.Аюуш: Хурал хаасныг мэдэгдэв.

Хурал 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 15 цаг 45 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: 3.ОТГОНБАЯР

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА: Б.АЮУШ